



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/537

Булган сум

140 бүл зөгийг хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 220513/04-249 дүгээр гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" /Булган/ төсөл, арга хэмжээний 5 дугаар багцаас нийлүүлж буй 140 бүл зөгийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Одхүү ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн захирал)

Гишүүд: Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)
Ц.Бямбацогт (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Лхагваням ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн менежер)

2. Стандартын шаардлага хангасан зөгийн бүлийг хүлээн авч, хууль тогтоомжийн дагуу баримт бичиг бүрдүүлж ажиллахыг ажлын хэсэг (Б.Одхүү)-т үүрэг болгосугай.

3. Зөгийн бүлийг аймгийн Засаг даргын баталсан хуваарь, төлөвлөгөөний дагуу сумдад нийлүүлэх, хадгалалт хамгаалалтыг хариуцаж ажиллахыг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК (Б.Одхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ